ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: buyanaa99042824@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

  2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

  2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

  2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

  2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

  2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................8

  3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

  3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

  3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........................................13

  4.1 Ерөнхий зүйл ........................................13

  4.2 Материаллаг байдал ........................................14

  4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................14

  4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..................14

  4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..................15

  4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................16

5. Аудитын илрүүлэлт ........................................16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 32

танай ______ -ны № ______ -т

БАЯНТЭС СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БАЗАРСАД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавары дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвд 2024 онд Эрүүл мэндийн яамнаас 160,000.0 мянган төгрөгийн түргэн тусламжийн автомашин, 21,307.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, төсвийн хөрөнгөөр 29,850.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авчээ.

Аудитын гол асуудал

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй УАЗ-22069 фургон автомашин, мотоцикл, принтер, билиметр зэрэг элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 37,400.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, хог хаягдал хортон шавьж устгах зардлаас бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авч, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвд сумын 100 жилийн ойгоор нутгийн зөвлөлөөс хандиваар ирсэн амбулаторын иж бүрдэл, шарлагын аппарат, камер зэрэг 23,600.0

тоног төхөөрөмж данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **173,630,893.49** | **320,857,934.39** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **110,036,512.38** | **85,678,794.80** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 110,036,512.38 | 85,678,794.80 |
| 31210 | Төгрөг | 110,036,512.38 | 85,678,794.80 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 110,036,512.38 | 85,678,794.80 |
| **33** | **АВЛАГА** | **11,517,486.00** | **170,966,582.48** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 11,517,486.00 | 170,966,582.48 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **52,076,895.11** | **64,212,557.11** |
| 35100 | Түүхий эд материал | 10,403,082.79 | 15,481,459.79 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,069,630.00 | 3,552,167.00 |
| 35130 | Эм боох материал | 7,333,452.79 | 11,929,292.79 |
| 35400 | Хангамжийн материал | 41,673,812.32 | 48,731,097.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 180,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,895,052.32 | 22,431,767.32 |
| 35460 | Хүнсний материал | 4,643,660.00 | 2,584,380.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,135,100.00 | 23,534,950.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **319,494,135.94** | **500,757,178.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **319,494,135.94** | **500,757,178.00** |
| 39200 | Биет хөрөнгө | 307,620,135.94 | 488,883,178.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 189,700,303.06 | 189,700,303.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (34,896,632.02) | (42,018,477.94) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,681,428.60 | 218,681,428.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (40,774,458.01) | (49,864,662.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 160,828,072.06 | 235,585,121.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (28,694,431.31) | (65,296,429.63) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,305,000.00 | 6,305,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (3,529,146.44) | (4,209,104.96) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 11,874,000.00 | 11,874,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,874,000.00 | 11,874,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **493,125,029.43** | **821,615,112.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | | **3,618,140.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **3,618,140.00** |
| 41300 | Өглөг | | 3,618,140.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 3,618,140.00 |
| 413209 | Эмийн өглөг | | 3,618,140.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **493,125,029.43** | **817,996,972.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **493,125,029.43** | **817,996,972.39** |
| 51101 | -Төрийн | 287,979,068.07 | 287,979,068.07 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 174,682,005.53 | 499,553,948.49 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 76,475,881.74 | 174,682,005.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 98,206,123.79 | 324,871,942.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 30,463,955.83 | 30,463,955.83 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **493,125,029.43** | **821,615,112.39** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **793,648,288.87** | **1,214,338,549.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **93,274,446.83** | **214,957,184.91** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 93,274,446.83 | 214,957,184.91 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,329,140.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 335,240.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 2,993,900.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 81,337,500.10 | 204,907,049.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 8,607,806.73 | 10,050,135.31 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,373,842.04** | **999,381,364.81** |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,678,300.00 | 35,363,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,678,300.00 | 31,863,400.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймаг, нийслэлээс авсан санхүүгийн дэмжлэг/ | | 3,500,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | | 27,500,000.00 |
| 133004 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | | 27,500,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 672,695,542.04 | 936,517,964.81 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 672,695,542.04 | 936,517,964.81 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **692,504,665.60** | **889,466,606.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **692,504,665.60** | **889,466,606.76** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 686,149,745.14 | 888,662,067.00 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 387,531,985.41 | 565,876,303.56 |
| 210101 | Үндсэн цалин | 262,745,173.20 | 328,865,766.13 |
| 210102 | Нэмэгдэл | 76,910,413.56 | 176,193,277.43 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 4,831,000.00 | 12,227,000.00 |
| 210104 | Урамшуулал | 43,045,398.65 | 48,590,260.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,530,349.54 | 69,426,728.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,760,140.87 | 47,993,471.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,971,781.36 | 5,817,163.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,124,625.05 | 2,855,781.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,414.06 | 2,552,062.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,984,388.20 | 10,208,249.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,521,179.54 | 28,062,660.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,614,299.54 | 3,271,344.24 |
| 210302 | Түлш, халаалт | 20,906,880.00 | 24,791,316.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 88,253,277.99 | 66,390,042.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,144,300.00 | 2,563,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,662,462.00 | 51,748,012.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,000.00 | 1,200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,312,000.00 | 325,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,810,812.98 | 10,553,430.00 |
| 2105 | Нормативд зардал | 55,883,242.40 | 61,678,097.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,499,577.40 | 52,160,217.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,383,665.00 | 9,517,880.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,180,200.00 | 15,266,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,180,200.00 | 15,266,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,881,700.00 | 9,152,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,881,700.00 | 9,152,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,528,392.00 | 2,604,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,046,800.00 | 1,657,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 171,000.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,600.00 | 148,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 44,608.00 |
| 210807 | Газрын төлбөр | 94,992.00 | 94,992.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,839,418.26 | 70,205,085.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,777,333.00 | 16,711,078.31 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 43,062,085.26 | 53,494,007.54 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,354,920.46 | 804,539.76 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,354,920.46 | 804,539.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,354,920.46 | 804,539.76 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **101,143,623.27** | **324,871,942.96** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,937,499.48** | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 2,937,499.48 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,937,499.48 | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **98,206,123.79** | **324,871,942.96** |

**2.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **692,185,496.04** | **839,932,268.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,329,140.00** | |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 3,329,140.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,329,140.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 335,240.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 2,993,900.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **688,856,356.04** | **839,932,268.33** |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,678,300.00 | 35,363,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,678,300.00 | 31,863,400.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймаг, нийслэлээс авсан санхүүгийн дэмжлэг/ | | 3,500,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | | 27,500,000.00 |
| 133004 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | | 27,500,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 661,178,056.04 | 777,068,868.33 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 661,178,056.04 | 777,068,868.33 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **630,362,408.95** | **834,439,985.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **630,362,408.95** | **834,439,985.91** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 624,007,488.49 | 833,635,446.15 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 387,531,985.41 | 565,876,303.56 |
| 210101 | Үндсэн цалин | 253,394,201.99 | 324,412,526.14 |
| 210102 | Нэмэгдэл | 86,761,384.77 | 180,646,517.42 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 4,831,000.00 | 12,227,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,545,398.65 | 48,590,260.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,530,349.54 | 69,426,728.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,760,140.87 | 47,993,471.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,971,781.36 | 5,817,163.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,124,625.05 | 2,855,781.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,414.06 | 2,552,062.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,984,388.20 | 10,208,249.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,921,179.54 | 28,062,660.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,614,299.54 | 3,271,344.24 |
| 210302 | Түлш, халаалт | 20,306,880.00 | 24,791,316.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 60,170,762.00 | 66,423,012.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,111,300.00 | 2,743,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,662,462.00 | 51,748,012.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,000.00 | 1,200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,607,000.00 | 765,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,490,000.00 | 9,966,400.00 |
| 2105 | Нормативд зардал | 58,820,360.00 | 59,967,759.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 47,131,170.00 | 51,002,159.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,564,190.00 | 7,458,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 125,000.00 | 1,507,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,180,200.00 | 15,266,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,180,200.00 | 15,266,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,881,700.00 | 9,152,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,881,700.00 | 9,152,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,528,392.00 | 2,604,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,046,800.00 | 1,657,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 171,000.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,600.00 | 148,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 44,608.00 |
| 210807 | Газрын төлбөр | 94,992.00 | 94,992.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,442,560.00 | 16,855,833.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,442,560.00 | 16,855,833.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,354,920.46 | 804,539.76 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,354,920.46 | 804,539.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,354,920.46 | 804,539.76 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **61,823,087.09** | **5,492,282.42** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ** | **10,644,800.00** | **29,850,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,644,800.00** | **29,850,000.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 10,644,800.00 | 29,850,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,644,800.00 | 29,850,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(10,644,800.00)** | **(29,850,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | **51,178,287.09** | **(24,357,717.58)** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **58,858,225.29** | **110,036,512.38** |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **110,036,512.38** | **85,678,794.80** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **287,979,068.07** | **32,724,689.70** | **74,215,147.87** | **394,918,905.64** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,260,733.87 | 2,260,733.87 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 287,979,068.07 | 32,724,689.70 | 76,475,881.74 | 397,179,639.51 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | (2,260,733.87) | | (2,260,733.87) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 98,206,123.79 | 98,206,123.79 |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **287,979,068.07** | **30,463,955.83** | **174,682,005.53** | **493,125,029.43** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 287,979,068.07 | 30,463,955.83 | 174,682,005.53 | 493,125,029.43 |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **324,871,942.96** | **324,871,942.96** |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **287,979,068.07** | **30,463,955.83** | **499,553,948.49** | **817,996,972.39** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *-/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | | | | Дүнгээр |
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | **110,036,512.38** | |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | **110,036,512.38** | |
| **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **1,016,905,200** | **832,426,585.91** | **184,478,614.09** |
| **80302** | **Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон** | **687,279,900** | **595,151,975.91** | **92,127,924.09** |
| **12** | **Татварын бус орлого** | **687,279,900** | **515,447,083.85** | **171,832,816.15** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **687,279,900** | **515,447,083.85** | **171,832,816.15** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 687,279,900 | 515,447,083.85 | 171,832,816.15 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ** | **687,279,900** | **595,151,975.91** | **92,127,924.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **687,279,900** | **595,151,975.91** | **92,127,924.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **687,279,900** | **595,151,975.91** | **92,127,924.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **602,172,000** | **517,286,043.56** | **84,885,956.44** |
| 210101 | Үндсэн цалин | 351,296,000 | 324,412,526.14 | 26,883,473.86 |
| 210102 | Нэмэгдэл | 244,804,000 | 180,646,517.42 | 64,157,482.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,072,000 | 12,227,000.00 | (6,155,000.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **75,271,500** | **69,426,728.35** | **5,844,771.65** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,184,600 | 47,993,471.46 | 3,191,128.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,021,700 | 5,817,163.08 | 204,536.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,010,900 | 2,855,781.50 | 155,118.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,010,900 | 2,552,062.47 | 458,837.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,043,400 | 10,208,249.84 | 1,835,150.16 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,861,000** | **1,404,470.00** | **456,530.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,861,000 | 1,404,470.00 | 456,530.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **5,350,100** | **4,488,434.00** | **861,666.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,121,100 | 2,382,134.00 | 738,966.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,229,000 | 2,106,300.00 | 122,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,625,300** | **2,546,300.00** | **79,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,625,300 | 2,546,300.00 | 79,000.00 |
| **81603** | **Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ** | **235,773,100** | **161,875,462.00** | **73,897,638.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **235,773,100** | **205,068,076.20** | **30,705,023.80** |
| **12000** | **Нийтлэг татварын бус орлого** | **110,036,500** | | **110,036,500.00** |
| 120009 | Бусад орлого | 110,036,500 | | 110,036,500.00 |
| **12200** | **Тусламжийн орлого** | **125,736,600** | **205,068,076.20** | **(79,331,476.20)** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 125,736,600 | 205,068,076.20 | (79,331,476.20) |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ** | **235,773,100** | **161,875,462.00** | **73,897,638.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **235,773,100** | **161,875,462.00** | **73,897,638.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **235,773,100** | **161,875,462.00** | **73,897,638.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **58,600,000** | **48,590,260.00** | **10,009,740.00** |
| 210104 | Урамшуулал | 58,600,000 | 48,590,260.00 | 10,009,740.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,325,000** | | **7,325,000.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,981,000 | - | 4,981,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 586,000 | - | 586,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 293,000 | - | 293,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 293,000 | - | 293,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,172,000 | - | 1,172,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **65,676,200** | **48,885,622.00** | **16,790,578.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,619,000 | 2,743,600.00 | 1,875,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,328,600 | 38,007,422.00 | 10,321,178.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,221,900 | 1,200,000.00 | 3,021,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 193,500 | 765,000.00 | (571,500.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,313,200 | 6,169,600.00 | 2,143,600.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **56,773,600** | **40,482,730.00** | **16,290,870.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,891,600 | 35,017,730.00 | 8,873,870.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,607,000 | 3,958,000.00 | 5,649,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,275,000 | 1,507,000.00 | 1,768,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,350,000** | **8,889,600.00** | **19,460,400.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 17,400,000 | 850,000.00 | 16,550,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,950,000 | 8,039,600.00 | 2,910,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,120,000** | **8,188,400.00** | **2,931,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,120,000 | 8,188,400.00 | 2,931,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,553,300** | **2,473,050.00** | **1,080,250.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,778,600 | 1,526,100.00 | 252,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000 | 540,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 420,300 | 119,250.00 | 301,050.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,100 | 148,100.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,200 | 44,608.00 | 54,592.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 121,000 | | 121,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 95,100 | 94,992.00 | 108.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 351,000 | | 351,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,375,000** | **4,365,800.00** | **9,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,375,000 | 4,365,800.00 | 9,200.00 |
| **83603** | **Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан** | **93,852,200** | **75,399,148.00** | **18,453,052.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **93,852,200** | **87,553,708.28** | **6,298,491.72** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,993,900 | 3,500,000.00 | 31,493,900.00 |
| **12200** | **Тусламжийн орлого** | **58,858,300** | **84,053,708.28** | **(25,195,408.28)** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 58,858,300 | 84,053,708.28 | (25,195,408.28) |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ** | **93,852,200** | **75,399,148.00** | **18,453,052.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **93,852,200** | **75,399,148.00** | **18,453,052.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **89,852,200** | **75,399,148.00** | **14,453,052.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,793,900** | **16,132,920.00** | **1,660,980.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,293,900 | 12,336,120.00 | (42,220.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000 | | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000 | 3,796,800.00 | 1,203,200.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **15,000,000** | **14,996,595.00** | **3,405.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,000,000 | 13,602,295.00 | (1,602,295.00) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 3,000,000 | 1,394,300.00 | 1,605,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **41,250,000** | **33,230,500.00** | **8,019,500.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 36,500,000 | 29,000,000.00 | 7,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,750,000 | 4,230,500.00 | 519,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,000,000** | **964,000.00** | **36,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000 | 964,000.00 | 36,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **450,000** | **131,400.00** | **318,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 450,000 | 131,400.00 | 318,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,358,300** | **9,943,733.00** | **4,414,567.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,358,300 | 9,943,733.00 | 4,414,567.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,000,000** | | **4,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000 | | 4,000,000.00 |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **85,678,794.80** | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | **85,678,794.80** | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **31,863,400.00** | **31,058,860.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,863,400.00** | **31,058,860.24** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,863,400.00** | **31,058,860.24** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,863,400.00 | 28,062,660.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,894,900.00 | 3,271,344.24 |
| 210302 | Түлш, халаалт | 24,490,400.00 | 24,791,316.00 |
| 210303 | Цэвэр бохир ус | 478,100.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 2,996,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,996,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **31,863,400.00** | **31,863,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **31,863,400.00** | **31,863,400.00** |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 31,863,400.00 | 31,863,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,863,400.00 | 31,863,400.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 804,539.76 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл:**

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу тусламж үйлчилгээ явуулдаг.

***Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зорилго:***
**Зорилт**: Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн зүй тогтлыг алдагдуулахгүйгээр өнөөгийн шинэ шатанд гаргаж уламжлалт анагаах ухаан эмчилгээ үйлчилгээний цогц төв болж, иргэдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхэд оршино. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.3 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянтэс сумын эрүүл мэндийн төвийн *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Эрүүл мэндийн тухай хууль

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль
11. Төрийн хэмнэлтийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус төв нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 328,490.1 мянган төгрөгөөр буюу 60.0 хувиар өссөн.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 11.517,5 | 170,966.6 | 159,449.1 |
| Бараа материал | 52,076.9 | 64,212.5 | 12,135.6 |
| Үндсэн хөрөнгө | 319,494.1 | 500,757.1 | 181,263.0 |
| **Нийт хөрөнгө** | **493,125.0** | **821,615.1** | **328,490.1** |
| Засгийн газрын хувь оролцоо /Өздийн өмч/ | 493,125.0 | 817,996.9 | 324,871.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **493,125.0** | **821,615.1** | **328,490.1** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 11,517.5 мянган төгрөг, тайлант оны авлагын эцсийн үлдэгдэл 159,449.1 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байна.
Бараа материалын эхний үлдэгдэл 52,076.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 151,081.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 10,050.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 148,995.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 64,212.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,135.6 мянган төгрөгөөр өссөн байна.
Үндсэн хөрөнгийн хувьд 29,850.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 204,907.0 мянган төгрөгийн Эрүүл мэндийн яамнаас түргэн тусламжийн машин болон бусад тоног төхөөрөмжийг орлогод авч, жилийн эцэст 500,757.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 53,494.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 324,871.2 мянган төгрөгөөр өсөж, тайлант онд өөрчлөлт орсон болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,048,768.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1,048,768.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,048.768.6 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, төсвийн гүйцэтгэл 863,485.4мянган төгрөг буюу 82.38 хувьтай байна. Энэ нь санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | **1,048,768.60** | **863,485.45** | **185,283.15** | **82.3** |
| 80109 | ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 31,863.40 | 31,058.86 | 804.54 | 97.5 |
| 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 687,279.90 | 595,151.98 | 92,127.92 | 86.6 |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 235,773.10 | 161,875.46 | 73,897.64 | 68.7 |
| 83603 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 93,852.20 | 75,399.15 | 18,453.05 | 80.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 31,863.4 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан хуваарийн дагуу зарцуулсан байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Харьцуулалтын арга | Эм, эмнэлгийн хэрэгсэл | 43,891.6 | 51,902.1 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Хангамжийн зардал | 65,676.2 | 66,423.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалтын зардал | 24,490.4 | 24,791.3 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгааны зардал | 3,894.9 | 3,271.3 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засварын зардал | 13,000.0 | 15266.3 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,742.5 | 2.604.4 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардал | 29,850.0 | 29,850.0 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Хоол | 9,607.0 | 7,458.6 |
| | | **ДҮН** | **193,630.7** | **201,567.0** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Баянтэс сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 692,185.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,921.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,537.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баянтэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

## 4.6Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,165.0 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж өглөө.

***Залруулсан алдаа: байхгүй***

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:*** УАЗ-22069 фургон, 3 ширхэг мотоцикл, принтер, билиметр зэрэг элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 37,400.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:***

Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:*** Хог хаягдал хортон шавж устгах зардлаас бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авч, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>***: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийж байх

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 38,165.0 мянган төгрөгийн зөрчлөөс 37,400.0 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж, 765.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 37,400.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 37,400.0 | | | | | 1 | 37,400.0 | | | | |
| Хог хаягдал хортон шавж устгах зардлаас БҮТЭЗ худалдан авсан | 1 | 765.0 | | | | | 1 | 765.0 | | | | |
| **Дүн** | **2** | **38,165.0** | | | | | **2** | **38,165.0** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-14

АТА6366 9039376 0521100609

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24